



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/511

Чингис хот

Түр журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3 “в”, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.10, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалтууд, Байгаль орчны сайдын 2002 оны 117 дугаар тушаалаар батлагдсан “Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал явуулах журам”-ын 1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Онон-Балжийн байгалийн цогцолборт газрын орчны бүсийн Хэнтий аймгийн Дадал, Биндэр, Батширээт, Баян-Адрага, Норовлин сумдын цогцолборт газрын зөвшөөрөгдсөн бүсэд эко гэр ажиллуулах түр журмыг хавсралтаар баталсугай.

2.Эко гэр ажиллуулах түр журмын дагуу үйл ажиллагаа явуулж буй иргэнтэй гурвалсан гэрээ байгуулж, журмыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онон-Балжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга (О.Цэндгомбо)-д, холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011674

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ОРЧНЫ БҮСИЙН СУМДАД
ЭКО ГЭР АЖИЛЛУУЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1. Энэхүү журмын зорилго нь Онон-Балжийн БЦГ-ын орчны бүсийн Хэнтий аймгийн Биндэр, Баян-Адрага, Дадал, Норовлин, Батширээт сумдын нутаг дэвсгэрт нутгийн иргэд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж, гадаад дотоодын аялагч жуулчдыг хүлээн авах, үйлчилгээг үзүүлэх эко гэр ажиллуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь Аялал жуулчлалын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Татварын тухай, бусад Монгол улсын хууль түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм журамтай нийцсэн байна.

Хоёр. Эко гэр ажиллуулах хүсэлт гаргах

2.1. Тухайн орон нутгийн иргэн эко гэр ажиллуулах тухай хүсэлтээ Онон-Балжийн Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд бичгээр гаргана. Эко гэрийг цогцолборт газрыг аялал жуулчлалын болон хязгаарлалтын бүсэд ажиллуулна.

2.2. Эко гэр ажиллуулах тухай хүсэлтээ Тусгай хамгаалалттай газар нутгийн Хамгаалалтын захиргаанд үйл ажиллагаа эхлэхээс 14 хоногийн өмнө ирүүлнэ.

2.3. Хамгаалалтын захиргаа нь сумын Засаг даргатай зөвшилцөн тухайн хүсэлтийг хүлээн авч судлан 14 хоногийн дотор хариуг хүргүүлнэ.

Гурав. Эко гэрт тавигдах шаардлага

3.1. Тухайн орон нутаг, багт оршин суудаг өрхөд эко гэр ажиллуулах эрхийг олгох бөгөөд нэг өрх 3-аас илүү гэр барихгүй байх.

3.2. Эко гэр ажиллуулж буй иргэд нь гэрийн хэлбэр хэмжээг нэгэн жигд, байгалийн аюултай үзэгдэл аадар бороо, мөндөр, галын аюул, салхи шуурганд амрагчдын ая тух, аюулгүй байдлыг хангахуйц бат бэх байлгах.

3.3. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд нийтийн хоолны газрын эрүүл ахуйн нийтлэг дүрмийг мөрдөх.

3.4. Эко гэр ажиллуулж буй өрх тус бүр бохир цуглуулах цооногтой байх.

3.5. Хамгаалалтын захиргаанаас зөвшөөрөл олгосон газарт түүх соёлын дурсгалт зүйлс болон гол, нуурын энгийн хамгаалалтын бүсийн гадна байрлаж үйл ажиллагаагаа явуулах.

3.6. Эко гэр ажиллуулж буй иргэн эко гэрээ авто замаас 200 метрээс холгүй зайтай байрлуулах, олон салаа зам гаргахгүй байх

3.7. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үе шатны төлөвлөгөө гаргаж хамгаалалтын захиргаагаар батлуулсан байх.

3.8 Зөөврийн эко 00-той байх

3.9 Ангилсан хогийн сав байрлуулсан байх

Дөрөв. Эко гэр ажиллуулж буй иргэний эрх, үүрэг

4.1 Эко гэр ажиллуулж буй иргэн дараах эрхтэй байна.

4.1.1 Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон асуудлаар Хамгаалалтын захиргаа, холбогдох байгууллагуудаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах

4.1.2. Хамгаалалтын захиргааны зөвшөөрлийн дагуу тухайн нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээ, эко гэр, морин аялал болон бусад үйл ажиллагааг явуулна.

4.1.3. Эко гэр ажиллуулах зөвшөөрөл авч гэрээ байгуулсан иргэн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх. Шаардлагатай тохиолдолд идэвхитэн байгаль хамгаалагч томилон ажиллуулах асуудлыг сумын Засаг дарга, Онон-Балжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаанд тавьж шийдвэрлүүлэх

4.2. Эко гэр ажиллуулж буй иргэн дараах үүрэгтэй

4.2.1. Эко гэр ажиллуулж буй иргэн Аялал жуулчлалын тухай, ТХГН-ийн тухай, Орчны бүсийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын унэлгээний тухай, Татварын тухай, бусад Монгол улсын хууль түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм журмыг мөрдөж ажиллах.

4.2.2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу үйл ажиллагаа явуулсны татварыг сум орон нутгийн орлогод төвлөрүүлэх

4.2.3. Эко гэр ажиллуулах шаардлага хангасан иргэд нь Хамгаалалтын захиргаа сумын ЗДТГ-тай гурвалсан гэрээ байгуулан ажиллах

4.2.4. Гадаад дотоодын жуулчид, амрагчдын бүртгэлийг хөтлөх, гадаад болон дотоодын аялагч жуулчдын урсгал хөдөлгөөн, статистик мэдээ тайланг хамгаалалтын захиргаанд холбогдох маягтын дагуу тайлагнаж байх.

4.2.5. Эко гэр ажиллуулж буй өрхүүд хариуцан хамгаалах орчны 500м талбайд хог хаягдлыг цэвэрлэж зайлуулах, хөрсний бохирдол, эвдрэлээс хамгаалах арга хэмжээг авах.

4.2.6. Эко гэр ажиллуулж байгаа өрхүүд нь тээврийн хэрэгслийн зогсоол гаргаж салаа зам гаргахгүй, машин техник явахыг хориглосон замын хаалт, тэмдэглэгээ хийх.

4.2.7. Эко гэр бусад үйл ажиллагаа явуулж буй иргэд зөвшөөрсөн газарт контэйнер тавих, шон хатгах, жижиг барилга байгууламж барихгүй байх,

4.2.8. Морин аяллаар үйлчилж буй иргэд шаардлага хангасан иж бүрэн тоноглол бүхий номхон мориор үйлчлэх, аялагч, жуулчдын асуулгүй ажиллагааг бүрэн хангасан байх.

4.2.9. Хамгаалалтын захиргаанаас зөвшөөрөл авсан талбайд зөвхөн эко гэр байрлуулж, мал аж ахуйгаа эрхлэн явуулдаг айл өрх гэрээ эко гэрээс 3 км-ээс ойргүй зайтай байлгах.

4.2.10. Эко гэр бусад үйл ажиллагаа явуулж буй иргэд орчны хог хаягдлаа цэвэрлэж зайлуулах ажилд хүн хүч гарган хамтран ажиллах.

4.2.11. Тухайн нутаг дэвсгэрийн хамгаалалтын горимыг чанд дагаж мөрдөхийн хамт үйл ажиллагаа /гэрээний хугацаа/ дууссаны дараа газрыг бүрэн цэвэрлэж гэрээлсэн талуудад хүлээлгэн өгнө.

Тав. Онон-Балжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа болон сумын ЗДТГ-ын эрх үүрэг

5.1. Эко гэр ажиллуулах тухай төсөл, хүсэлт ирүүлсэн иргэний шаардлага хангасан өрхүүдтэй гурвалсан гэрээ байгуулан ажиллах.

5.2 Гэрээний хугацаа 06 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 01-нийг хүртэл байна.

5.1.1. Хамгаалалтын захиргаа сумын Засаг даргатай хамтран тухайн нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээ, эко гэр, морин аялал болон бусад үйл ажиллагаанд хяналт тавих, дүгнэлт гаргана.

5.1.2. Дүгнэлтийг үндэслэн гэр буудалд тавигдах стандартыг хангасан айл өрхүүдтэй гэрээ байгуулж, эрх олгоно.

5.1.3. Тухайн иргэн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхэд хяналт тавина.

5.1.4. Хамгаалалтын захиргаа болон сумын Засаг дарга эко гэр ажиллуулах иргэдийг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллах.

5.1.6. Түр зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулах иргэдийг бүлэг, нөхөрлөлийн хэлбэрт оруулах замаар тодорхой зохион байгуулалтанд оруулах асуудлыг харилцан зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэх.

5.2. Хэрэв тухайн иргэн зөвшөөрснөөс өөр үйл ажиллагаа явуулсан эсвэл гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зэрэг тохиолдолд гэрээг цуцалж зөвшөөрөл авсан газраас нүүлгэх арга хэмжээ авна.

5.3. Эко гэр ажиллуулах шаардлага хангасан иргэнд үйл ажиллагаа явуулах газар, хариуцан хамгаалах талбайг нь заан өгч тэмдэгжүүлнэ.

5.4. Эко гэртэй байгуулсан гэрээний хэрэгжилтийн тайлан болон холбогдох судалгаа мэдээг гэрээлсэн талуудад ирүүлж байх

Зургаа. Бусад

6.1. Гэрээ байгуулсан өдрөөс эко гэр ажиллуулах айл өрхийн үйл ажиллагаа явуулах эрх үүснэ.

6.2. Хамгаалалтын захиргаа болон сумын Засаг дарга нь гэрээ байгуулсан айл өрхүүдэд гэр барих газар заан өгч төвлөрүүлэн үйл ажиллагааг эхлүүлнэ.

6.3. Эко гэр ажиллуулах шаардлага ханган гэрээ байгуулаагүй, гэрээнд тусгагдсан нөхцөл болзлыг зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгаа айл өрхүүдийн цаашид үйл ажиллагааг явуулах эрхийг шууд зогсооно.

6.4. Эко гэр ажиллуулж буй иргэн сум орон нутаг, хамгаалалтын захиргаанаас байгаль хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран оролцох

6.5. Хамгаалалтын захиргааны байцаагч, байгаль хамгаалагч, сумын байгаль хамгаалах хэсэг, бусад эрх бүхий албан тушаалтны тавьсан шаардлагыг сахин биелүүлэх.

Долоо. Журам хэрэгжих

7.1. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

-----oOo-----